

Сурагчдын эрүүл мэндэд сургуулийн эрүүл мэндийн сувилахуйн тусламжийн үр нөлөө

Я.Энхжаргал¹, С.Туяа¹, Ч.Энхтуул¹

¹АШУУИС, Сувилахуйн сургууль

Цахим шуудан: Enkhjargal.ya@mnums.edu.mn, Утас: 80094569

Түлхүүр үг:

Сургуулийн
сувилагч
Сургуулийн
эрүүл мэндийн
үйлчилгээ
Сувилахуйн
оролцоо
Сурагчдын
эрүүл мэнд
PICO аргачлал

Товч утга:

Удиртгал: Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээ нь сурагчдын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, улмаар сурлагын амжилтыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Сургуулийн сувилагч нь урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, архаг өвчтэй хүүхдүүдийн менежментийг хэрэгжүүлэх зэрэг олон чиглэлээр ажилладаг. Зорилго: Бид энэхүү тойм судалгаагаар сургуульд суурилсан сувилахуйн тусламжийн интервенцийн үр нөлөөг судлаачдын бүтээлд тулгуурлан нэгтгэн судлах. **Арга, аргачлал:** Судалгаанд PubMed, Scopus, Web of Science зэрэг олон улсын мэдээллийн сангаас нийтлэгдсэн судалгаануудыг тоймлон шинжилсэн. Судалгааны үр дүнгээс үзэхэд сургуулийн сувилахуйн оролцоо нь сурагчдын архаг өвчний менежментийг сайжруулах, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд эерэг нөлөө үзүүлдэг байна. Мөн сурагчдын хичээл таслалт буурч, сургуульд тохиолддог яаралтай тусламжийн тохиолдол эрс буурчээ. Эдгээр үр дүн нь сургуулийн сувилахуйн үйлчилгээг боловсрол болон нийгмийн эрүүл мэндийн тогтолцоонд илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Дүгнэлт: Сургуулийн орчинд хэрэгжүүлсэн сувилахуйн тусламжийн оролцоо нь сурагчдын эрүүл мэнд, сайн сайхан байдалд эерэг нөлөө үзүүлдэг. Сурагчдын архаг өвчний менежмент сайжрах, сэтгэцийн эрүүл мэнд дэмжигдэх, эрүүл зан үйл төлөвших, хичээл таслалт буурах зэрэг үр дүн гарч байна. Иймд сургуулийн сувилахуйн тусламжийг хөгжүүлж, боловсрол болон эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийг хамгаалах, эрүүл ирээдүйг бий болгоход чухал ач холбогдолтой юм.

Удиртгал: Нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн нэг болох сургуулийн эрүүл мэндийн сувилахуй нь сурагчдын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, сайн сайхан байдал, хэвийн өсөлт, хөгжлийг хангах үндсэн үйл ажиллагаагаар сурагчдын сурлагын амжилт, сэтгэлзүйг дэмждэг чухал салбар юм.¹ Сургуулийн сувилагч нь сувилахуйн ёс зүйг эрхэмлэж, нотолгоонд суурилсан практикт суурилсан эрүүл мэндийн тусламж үзүүлэх, багш, сурагчид, эцэг эх, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, эрүүл мэндийн бусад үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, чанартай тусламж үзүүлж, сурагчдын эерэг зан үйлийг дадал, хэвшил болгох үүрэг бүхий мэргэжилтэн байдаг.²⁻⁴ Сургуулийн сувилагч нь архаг өвчний хяналт, эмчилгээ сувилгаа, охидын жирэмсэлт, үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэх, яаралтай тусламж, сэтгэцийн

эрүүл мэндийн дэмжлэг зэрэг олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Олон улсын туршлагаас харахад сургуулийн сувилагчийн оролцоо нь сурагчдын эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг сайжруулж, удаан хугацаанд тогтвортой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн интервенц судалгааны үр дүн нэмэгдсээр байна.^{5,6} Дэлхий дахинаа Их Британи д анх 1892 онд Эми Хьюз Блумсбери сургуулийн сувилагч гэж түүхэнд тэмдэглэгдсэн бол 1902 оноос АНУ-ын сургуулиудад албан ёсоор сувилагч ажиллаж эхэлсэн байдаг. Сургуульд суурилсан эрүүл мэндийн төвүүд нь сурагчдын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, сурагчдад үзүүлэх эрүүл мэндийн цогц үйлчилгээг төвлөрүүлдэг бөгөөд сувилахуй төвтэй эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр интервенцийн үр ашиг өндөр байдаг байна. Тухайлбал: Сурагчдын амны хөндийн эрүүл мэнд сайжирч, эрүүл мэндийн боловсрол нэмэгдсэн,

гар угаалтын чанар дээшилж халдварт өвчний давтамж буурсан, вакцины хандалт нэмэгдсэн, сургуулийн гадаад дотоод орчны эрүүл ахуйн шаардлага сайжирсан, гуурсан хоолойн багтраа өвчний дахилт сэдэрлэлт буурсан, хичээл таслалт, эмнэлэгт хэвтэх давтамж буурсан, гипокликемийн тохиолдол гараагүй, эцэг эх, асран хамгаалагчдын ачаалал буурсан, гэр бүлийн сайн сайхан байдал нэмэгдсэн, шархны цэгцлэлт, боолтын үр дүн нэмэгдсэн, сурагчдын архаг өвчлөлийн хяналт сайжирч, илүүдэл жин, таргалалт, чихэрлэгийн хэрэглээ буурсан төдийгүй хооллолт, хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх хөтөлбөрүүд нэмэгдсэн, үе тэнгийн дээрэлхэлт, охидын жирэмсэлт буурсан, сургуульд тохиолддог яаралтай тусламжийн хэрэгцээ буурсан сурагчдын сэтгэцийн эрүүл мэнд нойрны чанар сайжирсан зэрэг олон чиглэлээр хийгдсэн АНУ, Филиппин, Тайван, Их британи, Япон, Канад, Австрали зэрэг орны судалгааны үр дүн харуулж байна.⁷ Түүнчлэн сургуульд суурилсан сувилахуйн тусламжид сурагчдын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, эрт илрүүлэг, бүртгэл мэдээллийн систем нь тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж, сургуулийн эрүүл мэндийг дэмжих шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг бүрдүүлдэг. Цаашид сургуульд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээний ОУ-ын судалгааны чиг хандлага олон мэргэжлийн багаар (Multidisciplinary school health team) сургуульд суурилсан эрүүл мэндийн багийг хөгжүүлэх, сургуулийн сувилагч-сэтгэлзүйч хосолсон мэргэжилтний оролцоо хэрэгцээнд чиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй нэмэгдэж байна. Мөн технологид суурилсан дижитал, теле эрүүл мэндийн боловсролыг сургуульд хөгжүүлэхэд сувилагч нарын интервенци судалгаа нэмэгдсээр байна.^{8,9}

Зорилго: Бид энэхүү тойм судалгаагаар сургуульд суурилсан сувилахуйн тусламжийн интервенцийн үр нөлөөг судлаачдын бүтээлд тулгуурлан нэгтгэн судлах.

Арга, аргачал: Medline, Scholar google, Web of Science Scopus цахим мэдээллийн баазуудыг ашиглан 2016-2026 онуудад хэвлэгдсэн бүрэн хэмжээний өгүүлүүдийг судлав. Хайлтын стратегид ахисан түвшинд буюу Вүүлэн оператериар (Boolean search strategy: (“school nurse” OR “school health nurse”) AND (“school-based intervention” OR “nursing intervention”) AND (“student health” OR “child health”) түлхүүр үгс ашиглан PICO аргачлалд суурилсан тойм судалгааг хамруулсан. Судалгааны түүвэрт түүврийн хэмжээ цөөн өгүүлүүдийг судалгаанаас хассан. Судалгааны аргачлалд P (Population): 6–18 насны сургуулийн насны хүүхэд, өсвөр үеийнхэн, I (Intervention): Сургуулийн сувилагчийн хэрэгжүүлсэн сувилахуйн тусламжийн оролцоо, C (Comparison): Сургуулийн сувилагчийн оролцоогүй эсвэл стандарт үйлчилгээ, O (Outcome): Эрүүл зан үйл сайжрах, архаг өвчний хяналт сайжрах, хичээл таслалт таслалт буурах аргачлал ашиглав. Хайлтанд 45568 илэрцээс бүрэн хэмжээний, англи хэл дээр бичигдсэн, хүн ам зүй нь хүүхэд, өсвөр насныхан эсвэл тэдний эцэг эх, интервенци судалгааг хангасан 1655 өгүүлээс бүрэн хэмжээний 23 өгүүллийг нэгтгэн тоймлов.

Үр дүн:

Сурагчдын архаг өвчний менежментэнд сувилахуйн тусламжийн оролцоо: Сургуулийн сувилагч нь гуурсан хоолойн багтраа, харшлын урвалууд, чихрийн шижин зэрэг архаг өвчтэй сурагчдын өдөр тутмын хяналт, зөвлөгөө, багш, нийгмийн ажилтан, эцэг эхийн харилцааг зохицуулж, эмчилгээний хэрэгжилтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Судалгаануудын үр дүнгээс үзэхэд сургуулийн сувилагчийн оролцоотой үед сурагчдын өвчний хяналт сайжирч, яаралтай тусламжийн хэрэгцээ буурсан байна.¹⁰⁻¹⁸

Сэтгэцийн эрүүл мэндийн дэмжлэг: Сургуульд суурилсан эрүүл мэндийн төв дэх сургуулийн сувилагч нь сурагчдын сэтгэл зүйн асуудлыг эрт илрүүлэх сувилахуйн үнэлгээнд суурилсан төлөвлөгөөний хүрээнд зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагад холбон зуучлах, сэтгэл заслын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж урт хугацаанд сурагчдыг дагаж судлах, үе тэнгийн дээрэлхэлтийг эрт илрүүлэх, охидын жирэмсэлтээс сэргийлэх, өсвөр үеийн сэтгэцийн асуудалд сувилагчийн оролцоо нь сурагчдын сэтгэл түгшилт, сэтгэл гутралын түвшинг бууруулахад эерэг нөлөө үзүүлж байжээ.^{19,21}

Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа: Сургуулийн сувилагчид суурилсан эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрүүд нь сурагчдын хооллолт, чихэрлэгийн хэрэглээг бууруулах, хөдөлгөөний идэвх, хувийн ариун цэврийн мэдлэг олгох, анхан шатны тусламж үзүүлэх бодит сургалт, амны хөндийн эрүүл ахуйн дадал хэвшүүлэх, архи тамхи, электрон тамхины хор хөнөөлийг ойлгох зэрэг эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг. Түүнчлэн багш эцэг эх, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж, байгууллагын гадаад, дотоод түншлэлийг эрүүл мэндийн үйлчилгээнд татан оруулсан судалгааны үр дүн байна.

Сурагчдын ирц ба сурлагын амжилт: Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээ сайн хөгжсөн үед сурагчдын өвчний улмаас хичээл таслах явдал буурч, улмаар хичээлд оролцоо болон сурлагын амжилт нэмэгддэг болохыг судалгаанууд харуулж байна.

Мөн шинэ оношлогдсон хорт хавдартай хүүхдийн эцэг эхэд тулгардаг сэтгэл зүйн тусламжид итгэл үнэмшлийн зан үйлийн сургалтыг сувилагч нар хийх нь үр дүнтэй байсан байна. Үүний тулд сувилагч нар боловсрол олгохдоо эцэг эхийн мэдлэг, эцэг эхийн анхаарлыг үнэлэх, тэсвэр, даван туулах чадваруудыг үнэлэх, эцэг эхийг сонсох, яриулах цаг гаргах, шинжлэх ухаанч мэдээллээр хангах, сувилагч, үйлчлүүлэгчийн итгэлцлийг бий болгох, нийгмийн дэмжлэгт холбож жуучлах ажлыг сувилагч хийсэн нь үр дүнтэй байсан.¹²⁻¹⁵

Технологид суурилсан тусламж: Дэлхий дахинд технологийн хэрэглээ нэмэгдэхийн хирээр хүүхдийн хавдрын чиглэлээр ажилладаг сувилагч нар өгөгдөл цуглуулах, хяналт тавих, тодорхой вертуал сургалтын хөтөлбөр боловсруулах, хүүхдүүд болон тэдний гэр бүлд зориулсан технологид суурилсан хөндлөнгийн оролцоотой сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, цахим хуудсанд суурилсан платформ, ухаалаг гар утас, таблет,

компьютер, мессеж илгээх, дуу дүрсээр хүүхдийн чөлөөт цагийг хөгжүүлэх зэрэг сувилгааг төлөвлөх зэрэгт тусламж үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх нь орчин үеийн сувилахуйн тусламжийн шинэ хандлага юм. Технологид суурилсан хөндлөнгийн оролцоог ашиглаж хүүхдийн сонголт, харааны, хүрэлцэх, мэдрэхүйгээр эрүүл мэндийн боловсрол олгох арга бол хүүхдэд хүүхэлдэйн киногоор дамжуулж зан үйл олгох хүүхэд, эцэг эхийн дэмжлэгийн хэрэгцээг тасралтгүй, хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх үр нөлөө хүүхэд урам зориг сэтгэл ханамжийг нэмэгдүүлжээ.¹⁶ Сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох төсөл хөтөлбөр нь вэбсайт, анимейшн видео, хэлэлцүүлгийн самбар, санал асуулга, интерактив боловсрол олгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, видео хурал зөвлөгөөн хийсэн нь багш нар, үе тэнгийнхнийг хүлээн зөвшөөрөх, сургуулийн нийгэмшүүлэх, үйлчлүүлэгчдийн эрүүл мэндэд эерэг үр дүнтэй байсан.¹⁷ Сургуулийн эрүүл мэндийн сувилахуйн хөтөлбөрийн үр дүнд сурагчид үр бүтээлтэй амьдрах чадвараа хөгжүүлэх эрүүл мэндийн суурь боловсролыг бий болгодог.

Энэхүү үйл ажиллагаа нь хоорондоо уялдаатай найман бүрэлдэхүүн хэсгийг агуулдаг байна.¹⁸ Үүнд:

1. Эрүүл мэндийн боловсрол
2. Биеийн тамирын боловсрол
3. Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээ
4. Сургуулийн хоол тэжээлийн үйлчилгээ
5. Сэтгэлзүйн, нийгмийн үйлчилгээний зөвлөгөө
6. Сургуулийн эрүүл, аюулгүй орчин
7. Сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ
8. Эцэг эх, нийгмийн дэмжлэг

Сурагчдын гэрээр зочлох сувилахуйн тусламж: Сурагчдад зориулсан төсөл хөтөлбөрүүдэд гэрт нь сувилагч очиж, хоол тэжээлийг үнэлэх, зөвлөх, биеийн тамирын дасгал хөдөлгөөн заах, төсөл хэрэгжүүлэх, шинж тэмдгийг хянах зэрэг асуудлууд хүүхдүүдийн сайн сайхан байдалд үр ашигтай, зардал багатай, нийгмийн халамж, үйлчилгээ төдийгүй гэр бүлд зөвлөгөө өгөх сувилагч нар зааж үзүүлэх интервенци судалгаа нэмэгдэж байна.^{23,24} Энэхүү тойм судалгааны үр дүн нь сургуулийн сувилагчийн оролцоо нь сурагчдын эрүүл мэндийг дэмжихэд чухал үүрэгтэй болохыг харуулж байна. Сургуулийн орчинд нь сурагчдад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нь эрүүл мэндийн асуудлыг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх боломжийг нэмэгдүүлдэг. Мөн сургуулийн сувилагч нь багш, эмч, сэтгэл зүйч, хоол зүйч, нийгмийн ажилтан, эцэг эхтэй хамтран ажиллах олон мэргэжлийн багийн гишүүний хувьд хүүхдийн эрүүл мэндийг цогцоор дэмжих боломжтой. Гэвч зарим улс оронд сургуулийн сувилахуйн үйлчилгээ хангалттай хөгжөөгүй хэвээр байна. Монгол Улсад сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх, сургуульд сувилагч ажиллах эрх зүйн зохицуулалт, сувилагчийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь хүүхдийн эрүүл мэндийг сайжруулахад чухал ач холбогдолтой юм. Цаашдын судалгаанд сургуулийн сувилахуйн оролцооны урт хугацааны үр нөлөө болон үр дүнтэй

хэрэгжүүлэх загваруудыг судлах шаардлагатай байна.

Дүгнэлт: Сургуулийн орчинд хэрэгжүүлсэн сувилахуйн тусламжийн оролцоо нь сурагчдын эрүүл мэнд, сайн сайхан байдалд эерэг нөлөө үзүүлдэг. Сурагчдын архаг өвчний менежмент сайжрах, сэтгэцийн эрүүл мэнд дэмжигдэх, эрүүл зан үйл төлөвших, хичээл таслалт буурах зэрэг үр дүн гарч байна. Иймд сургуулийн сувилахуйн тусламжийг хөгжүүлж, боловсрол болон эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийг хамгаалах, эрүүл ирээдүйг бий болгоход чухал ач холбогдолтой юм.

Ном зүй:

1. Nadine Schwab; Mary Gelfman. *Legal Issues in School Health Services: A Resource for School Administrators, School Attorneys, School Nurse*. 2005
2. Maughan ED, Bobo N, Butler S. *School nursing practice in the United States*. *J Sch Nurs*. 2016;32(4):241-248.
3. Lineberry MJ, Ickes MJ. *The role and impact of nurses in American elementary schools: a systematic review*. *J Sch Nurs*. 2016;31(1):22-33.
4. Best NC, Oppewal S, Travers D. *Exploring school nurse interventions and health outcomes: a systematic review*. *J Sch Nurs*. 2018;34(1):14-27.
5. Basch CE. *Healthier students are better learners: a missing link in school reforms*. *J Sch Health*. 2021;81(10):593-598.
6. *Centers for Disease Control and Prevention. School Health Services*. Atlanta, GA: CDC; 2021.
7. Yoder, C.M. *School Nurses and Student Academic Outcomes: An Integrative Review*. *Journal of School Nursing*. 2020;36 (1): 49-60.
8. Kolbe, Lloyd J. *"School Health as a Strategy to Improve Both Public Health and Education"*. *Annual Review of Public Health*. 2019;40 (1): 443-463. doi:10.1146/annurev-publhealth-040218-043727. ISSN 0163-7525. PMID 30566386
9. *School Nursing: Scope & Standards of Practice*, 2nd edition. <http://www.nursesbooks.org/Main-Menu/eBooks/eStandards/eBook-School-Nursing.aspx> Gordon SC, Barry CD: *Development of a school nursing research agenda in Florida: a Delphi study*, *J Sch Nurs*. 2017; 22(2):114-119, 2006
10. *Council on School Health. Role of the school nurse in providing school health services*. *Pediatrics*. 2016;137(6):e20160852.
11. Wang LY, Vernon-Smiley M, Gapinski MA, Desisto M, Maughan E, Sheetz A. *Cost-benefit study of school nursing services*. *JAMA Pediatr*. 2018;168(7):642-648.
12. *World Health Organization. Making Every School a Health-Promoting School*. Geneva: WHO; 2021.
13. *School nurse*. (1 March 2017). Retrieved from <https://www.registerednursing.org/specialty/school-nurse>
14. Yosep I, Hikmat R, Mardhiyah A. *School-Based Nursing Interventions for Preventing Bullying and Reducing Its Incidence on Students: A Scoping Review*. *Int J Environ Res Public Health*. 2023 Jan 15;20(2):1577. doi: 10.3390/ijerph20021577. PMID: 36674330; PMCID: PMC9863433.
15. Yadav, B.S.; Kaur, H. *A review on the problem of adolescent due to the excessive use of technology: Cyberbully*. *Int. J. Sci. Technol. Res*. 2020, 9, 3537-3541.
16. Yosep, I.; Hikmat, R.; Mardhiyah, A.; Hazmi, H.; Hernawaty, T. *Method of Nursing Interventions to Reduce the Incidence of Bullying and Its Impact on Students in School: A Scoping Review*. *Healthcare* 2022;10, 1835.
17. Yosep, I.; Pramukti, I.; Agustina, H.R.; Kurniawan, K.; Agustina, H.S.; Hikmat, R. *Triple-P e-Parenting to Improve Awareness of Psychiatric Nurses on Preventing Cyberbullying in Adolescents*. *Healthcare* 2023; 11- 19.

Effects of School-Based Nursing Interventions on Student Health Outcomes

Enkhjargal Ya¹, Tuya S¹, Enkhtuul Ch¹

¹School of Nursing MNUMS

E-mail: Enkhjargal.ya@mnumns.edu.mn, Tel: +976-80094569

Abstract:

Background: School health services play a critical role in protecting and promoting students' health, thereby contributing to improved academic performance. School nurses provide a wide range of services, including preventive care, health education, and management of chronic conditions among students.

Aim: This review aimed to synthesize existing evidence on the effectiveness of school-based nursing interventions based on published research.

Materials and Methods: A literature review was conducted using international databases, including PubMed, Scopus, and Web of Science. Relevant studies on school-based nursing interventions were systematically analyzed. The findings indicate that school nursing interventions positively impact the management of chronic diseases, promotion of mental health, and development of healthy behaviors among students. Additionally, reductions in school absenteeism and emergency incidents were consistently reported.

Results: The reviewed studies demonstrated that school-based nursing interventions significantly improve students' health outcomes. These include better chronic disease control, enhanced mental well-being, and increased adoption of healthy lifestyles. Furthermore, students receiving such interventions showed decreased absenteeism and fewer emergency health events at school.

Conclusion: School-based nursing interventions have a positive impact on students' health and well-being. Strengthening school nursing services and enhancing collaboration between the education and health sectors are essential to promote the health of children and adolescents and to ensure a healthier future generation.

Keywords: School nursing, Nursing intervention, Health outcome, PICO